

ЭЛЧИН САЙДЫН ТЭМДЭГЛЭЛ

Д.Баярхүү*

Судлаач профессор, дипломатч, Монгол Улсаас АНБЕУ-д суугаа Элчин сайд Д.Баярхүү NЕРКО publishing хэвлэлийн газартай гэрээлээд “БИ: Миний амьдралын тойрог” хэмээс дурдатгал номоо бичээд дуусчээ. Удахгүй хэвлэгдэх эл номоос түүний шинэ томилолт болох – Каирт Элчин сайдаар очоод бичсэн Миср нутаг дахь ажил амьдралын хэсгээс нь дор сийрүүлж уншигчиддаа сонирхуулья.

2008 оны хаврын хавсаргатай, бас хэдэн дусал бороотой өдөр бид төрөлх хотоосоо гарсан юм. Ингэхэд хаврын тарчиг цагаар Каир руу юундаа тэмүүлэв гэж ам асуух хүн гараад ирж магад. Юу гэвэл Египетийн Ерөнхийлөгч нь жилдээ 2 удаа, хавар намартаа гадаадын Элчин сайд нарын ИЖБ-г хүлээн авдаг, энэ оны эхнийх нь 4 дүгээр сард байж магад хэмээн Египетийн ГХЯ-наас Каир дахь манай ЭСЯ-нд мэдэгдсэний дагуу тэр жил томилогдсон Элчин сайд нараас би түрүүлэн Ерөнхийлөгчийн зарлиг гаргуулан ИЖБ-ээ гардан авч 3 дугаар сарын 27-нд яаравчлан ирсэн нь тэр байв. Бид 27-ны үүрээр 06.00 цагийн үед Каирын олон улсын нисэх онгоцны буудалд газардсан юм.

Манай ЭСЯ-ны зөвлөх бөгөөд Хэргийг түр хамаарагч Б.Баасансүрэн, III нарийн бичгийн дарга Д.Энхтайван, жолооч Д.Жадамба, Египетийн ГХЯ-ны Ёслолын газрын нэг хариуцлагатан иржээ. Тэд биднийг VIP заалаар угтан авлаа.

Миний хувьд өмнө нь Каирт хоёр удаа албан ажлаар ирж, хэд хонож байсных би эрхбиш гадарлана. Өмнө нь намайг хоёр удаа ирэх үед манай ЭСЯ Замалек гэж арал дээр Дипкорпусын хороолол маягтай ДТГ-ууд төвлөрсөн газар байрлаж байсан юм. Харин одоо хотын чанх зүүн өмнө зүгийн Maadi хэмээх алслагдсан дүүрэгт, шинэ байрандаа төвхнөжээ. Хоёр орны харилцааны хүрээ хязгаарлагдмал, иймд ажлын ачаалал нэг их бус, ёслол протокол, үйлчилгээний ажил тэр бүр ундраад байдаггүй. Тиймээс ч манай ЭСЯ-ыг орон тоо, зохион байгуулалтын хувьд төвөөс цомхон зохион байгуулж өгчээ.

Миний хувьд тус улсад суух 11 дэх Элчин сайд нь юм байна. Манай хоёр орны хооронд 1963.04.02-нд албан ёсоор Элчин сайдын хэмжээнд дипломат харилцаа тогтоожээ. Манай улс Прагад суугаа Элчин сайд Шадавын Цагаандоржийг 1963 онд Египетэд хавсран суух Элчин сайдаар, Египет улс Бээжинд суугаа Элчин сайд Захирия Аль-Адли Имамыг Монголд хавсран суух Элчин сайдаар 1963 онд тус тус

* Д.Баярхүү - судлаач профессор, дипломатч, Монгол Улсаас АНБЕУ-д суугаа Элчин сайд

томилсон ба Элчин сайд Ш.Цагаандорж 1964.02.26-нд Египетийн Ерөнхийлөгч Г.А.Нассерт ИЖБ-ээ барьжээ. Ингээд Ш.Цагаандорж нь 1963-1965 онд тус улсад эх орноо төлөөлжээ. Дараа нь Баярын Жаргалсайхан 1964-1969 онд, Балжины Лочин 1969-1972 онд, Цэвээнгомбын Дэмиддагва 1973-1977 онд, Далхын Лувсанринчин 1977-1982 онд, Содномдоржийн Дамбадаржаа 1982-1988 онд, Гонсүрэнгийн Дүгэрээ 1988-1991 онд, Ишцогийн Очирбал 1994-1997 онд, Калдырын Сайраан 1997-2001 онд, Чойжилжавын Болд 2001-2005 онд сууж байгаад бараг гурав жил Түр хамаарагчтай байсны эцэст би ирсэн нь тэр байв.

Намтар түүхээс нь харвал тус улсад манай үе үеийн нэртэй дипломатчид алба хашиж байжээ. Б.Жаргалсайхан нь ГЯЯ-ны сайд, С.Дамбадаржаа нь ГЯЯ-ны орлогч сайд байсныг лав нийтээрээ мэднэ. Нью Делид өмнөх Элчин сайд нарынхаа гэрэл зургийг хүндэтгэлтэй байрлуулж байсных би Б.Жаргалсайхан, Ц.Дэмиддагва нарын намтар түүхийг мэднэ. К.Сайрааныг УИХ-ын гишүүн байсан гэдгээр нь манайхан сайн мэдэх байх. Хаа очиж энэ 10 дотор мэргэжлийн бус, намын томилолттой намын ажилтан байхгүй. Тэр утгаар манай төр-засаг Каирт мөн л мэргэжлийн талаас хүч хаяж ирсэн бололтой юм.

Каир дахь ЭСЯ маань ингэхэд Африк, Ойрхи Дорнодод ажиллаж байгаа цорын ганц ЭСЯ юм. 1960 онд юм болов уу анх Гвиней улсад (Конакри хот) ЭСЯ-аа нээж ажиллуулж байгаад хэдэн жилийн дараа хаасан байдаг юм. Мали улсад (Бамако хот) ЭСЯ нээх шийдвэр гараад чимээгүй болсон, хожим нь Луандад (Ангол улс) ЭСЯ нээх асуудлыг шийдчихээд бас хэрэгжүүлээгүй, тэгж тэгж энэ Каир, Алжир хоёрт ЭСЯ ажиллуулж байгаад одоо Каир нь үлдээд байна.

Манай улс Каир хотноо байнгын Элчин сайдын яамаа 1967 онд нээгээд эдүгээ 42 жилийн нүүр үзжээ. Элчин сайд Б.Жаргалсайхан 1967.09.18-нд анх Прагаас Каирт шилжин ирж ажилдаа орсон юм билээ. Анхлан 1967 онд ЭСЯ нээгдэж байх үеэ тэрээр дурсахдаа:

- Каирт бид хэдэн арван байшин үзэж байж, хотын шинэ дүүргийн нэгэн чөлөөтэй саруул сайхан газар хараахан барьж дуусаагүй байсан авсаархан байрыг авч өөрсдийн хяналтын дор барилгын ажлыг дуусгав. Тэр хавьдаа ховорхон, цоо шинэ, тун цэвэр цэмцгэр байртай болов. Хашаан дотор маань шив шинэхэн тарьсан ногоон зүлгэн дээр нэгэн араб хүний бэлэглэсэн гөрөөсний хоёр янзага бэлчинэ гэжээ.¹

Сурвалжлаад байвал энэ гоё байр нь Zамалек арал дээр байсан юм шиг. Б.Жаргалсайхан гуайн үзэхээр дараагийн Элчин сайд Б.Лочин нь тэр сайхан хашаа байшин цэцэрлэгийг хотын төвд Mohandessin гэдэг дүүрэгт умгар хашаа бүхий байраар сольж, шилжиж орсон юм байна. Тэндээ 20 гаруй жил байрлаж байснаа Элчин сайд

И.Очирбалын үед хотын төвийн тэр хашаа байшингаа зараад хотын захад одоогийн энэ байрыг бариулж эхэлжээ. Энэ байрыг бариулахаар том нүх ухуулчихсан байхад нь 1996 онд, байшингаа яг барьж байхад нь 1998 онд би ирж байсан тул зах зухаас нь гадарлана. Намайг тэгж хоёр удаа Каирт очиход манай ЭСЯ Zamalek арал дээр нэгэн өндөр байшингийн хоёр давхрыг түрээслээд сууж байсан юм. Mohandessin дахь байраа сольж байгаагаа байшин нь хуучирч муудсан, илжирсэн, шал нь боссон, үнэр танар нь болохоо байсан гэдгээр л Очирбал гуай тайлбарлаад байснаас бус стратегийн чухал байршлаа алдаж байгаадаа дүгнэлт хийхгүй байв. Би ч гэж би, Каирт Элчин сайдаар сууна гэх төсөөлөл, тэмүүлэл тэр үед байгаагүй тул нэг чихээрээ оруулаад нөгөө чихээрээ гаргачихаж.

Ямар ч гэсэн тус ЭСЯ 40 гаруй жилийнхээ түүхэнд 4 удаа нүүж, нүүх тоолондоо шат уруудаж ирсэн юм байна гэсэн дүгнэлт одоо хийх дээрээ тулаад сууж байна. Өөрөө ирж ажиллаад, бие махбодоороо мэдрээд, ЭСЯ-аа ийнхүү хотын төвөөс холдуулж нүүлгэсний харгайгаар хот руу орж ажил хөөцөлдөх, ёслолын арга хэмжээнд оролцох, сургуулийн сурагчдыг хүргэх авах зэрэгт хоёр талдаа 30 ба түүнээс илүү олон км давхиж, маш их цаг зав, шатахуун гарздаж байгаад харамсаад ингэж дүгнэж байна. ЭСЯ маань орон сууцны чигжүү хороолол дунд байрласан, олон машин зогсох боломжгүй, нэг дор олон зочныг хүлээн авч зоог барих байр савны боломжгүй тул гадуур зочид буудал, зоогийн газар, хөлөг онгоцны баар түрээслэхээс өөр аргагүй юм байна. Энэ нь цаад утгаараа мөнгийг юүлж өгнө гэсэн үг. Нөгөө илжирсэн, үнэр танар нь болохоо байсан байрыг сольсноосоо дордуулахын цаагуур дордуулжээ. Өмнөх нөхдийнхөө хийсэн бүтээснийг энд харлуулах гээгүй, гэхдээ хойч үедээ үлдээсэн балаг гэж үзэхээс аргагүй нүгэл бол тэр байршлыг сольсон явдал яах аргагүй мөн юм.

За ингээд Каирт ирсэн тухайгаа үргэлжүүлэн хүүрнэе. Би өмнө нь гадаадын 109 орны ЭСЯ, НҮБ-ын бүсийн 19 байгууллага,² олон улсын бусад байгууллага ажилладаг Нью Делид ажиллаж байсных тэр талын тоон дээр судалгаа хийлээ. Каир бол Делигээс дутахааргүй бүс нутгийн төв – том хот, мэдээж маш том Дипкорпустай гэдгийг би мэдэж байлаа. Каирт 138 ЭСЯ байгаа нь лав миний үеийн Делигээс давчихаж. Арабын улсуудын Холбоо энд байрладаг ба тэнд суугаа БТГ гэвэл 10 орчим, Арабын улсуудын Холбооны дэргэд суугаа Африкийн Холбооны БТГ гэж тусдаа, мөн Арабын олон улсын байгууллагууд 8, НҮБ-ын бүсийн ба олон улсын бусад байгууллага нийлээд 33 болж байна. Мөн л Делигээс тооны хувьд давж байна³.

Каирт ирсэн даруйдаа миний хийх ёстой зайлшгүй чухал, гол ажил бол юуны өмнө Элчин сайд гэдгээ албажуулж албан ёсоор

ажилдаа орох явдал байв. Элчин сайд болох замналынхаа үлдэх хоёр шатыг гүйцээхээр ажиллав. Энэ нь тухайлбал Гадаад хэргийн сайдад нь ИЖБ-ийнхээ хувийг гардуулж ажилдаа орох, эцсийн шат нь суугаа улсынхаа Төрийн тэргүүнд ИЖБ-ээ барихыг хэлж байна.

Ингээд тус улсын Гадаад хэргийн сайд Ахмэд Абуль Гэйт, Гадаад хэргийн туслах сайд бөгөөд ГХЯ-ны Ёслолын газрын дарга Омар Митуали нарт 2008.04.03-нд бараалхаж ёслолын уулзалт хийлээ. Ноён Абуль Гэйтэд ИЖБ-ийнхээ араб, англи хэл дээрхи хувийг гардуулж ажилдаа албан ёсоор орлоо. Тухайн үед би тус улсын Төрийн тэргүүнд ИЖБ гардуулах гадаадын Элчин сайд нарын 13 дахь нь гэж ГХЯ-ных нь ёслолын жагсаалтад бүртгэгдлээ. ИЖБ-ийн хувийг гардан авахдаа ноён сайд Абуль Гэйт надад баяр хүргэн, миний азтайг гайхан ойрын нэг сарын дотор ИЖБ хүлээн авах жагсаалтад Та багтаж чадлаа. Тэр бүр ийм боломж Элчин сайд нарт тохиодоггүй юм. Тун удахгүй Та бүхний ИЖБ-г зохион байгуулна гэж амлав.

Тэр амлалтыг дахин 2 сар 20 хоног хүлээсэн юм даа. Бид ИЖБ барих тэр өдрийг 5 дугаар сарын турш хүлээв. ИЖБ барихаар надтай хамт жагсаалтад багтсан Элчин сайд нартай хүлээн авалт, бусад арга хэмжээний үед уулзах болгондоо харилцан мэдээлэл солилцож, сураг ажиг гаргаж байтал хүлээгдэж буй Элчин сайдын тоо юу юугүй 20-иос давлаа. ГХЯ-ны туслах сайд, Ёслолын ба чиглэлийн газрын албан хүмүүстэй уулзаж асуух бүрт “Very Soon” гэдэг хариулт л өгнө. Зарим дипломатчдын яриагаар намар болтол хойшилж мэдэх ч сураг гарч, ноднин 10-11 дүгээр сард ирсэн Элчин сайд нарын зарим нь бухимдангуй, гутранги явахтай нэг бус удаа таарч байв. Түрүүлж ирсэн Элчин сайд нарын нэлээд нь ЭСЯ-дын зохиож буй үндэсний баярын хүлээн авалтад үзэгдэхгүй болж, тэдний хувьд сэтгэлээр унасан юм уу гэмээр байдалтай явааг ажиглалаа. 2007 оны намраас хойш хүлээж байгаа Хятад, Индонез, Филиппиний сайд нарыг бодвол би сэтгэлээр унахаар ч биш юм.

Нэг өдөр гэнэгүй байж байтал ИЖБ барих товыг ГХЯ-наас нь гэнэт зарлаж түргэн авахуулав. Энэ бол 6 дугаар сарын 11 байлаа. Тэгснээ 15 хүртэл эргээд алга болчихов. Тэр өдөр үдээс хойш ажил тарахын алдад факсаар нэгэн ноот иржээ. Маргааш өглөө төдөн цагт бэлэн байх, юу юуг анхаарах зэргийг мэдэгджээ. Ерөнхийлөгчийн ордон руу авч явах ёслолын машины жолооч, хамгаалалтын ажилтан нар гэнэт ЭСЯ-нд ирээд хонх дуугарган сүр бараатай орж ирэв. Тэд маршруттайгаа танилцаж байгаа нь тэр гэнэ.

Ингээд хүсэн хүлээсэн ИЖБ барих өдөр маань ирлээ. 2008.06.16-ны өглөө 07.00 цагт ёслолын машин, мотоцикл хөлөглөсөн хамгаалалтын ажилтан намайг авахаар иржээ. Египетийн талын ёслолын журмаар бол ИЖБ барих гадаадын Элчин сайдыг

яамнаас нь хэн ч дагалддаггүй, зөвхөн ганцаараа айлын талын ёслолын машинаар явж, буцаж ирдэг юм байна. Бид 07.40 цагт ЭСЯ-наас хөдөлж 45 минут явсны дараа Ерөнхийлөгчийн ордонд хүрэлцэн очиж, хүлээлгийн танхимд бусад Элчин сайд нартай хамт суулгаалаа. Энд надаас гадна 5 тивийн 24 улсын Элчин сайд уван цуван хүрэлцэн ирцгээв. Үүнд

- Азийн 6: Монгол, Хятад, Индонез, Филиппин, Бангладеш, Узбекистан;
- Америкийн хоёр: АНУ, Панам;
- Европын 4: Мальта, Их Британи, Латви, Босни-Герцеговина;
- Африкийн 9: Эретрэй, Буркина-Фасо, Чад, Кот д'Ивуар, Намиби, Мали, Сенегал, Лесото, Свазиланд;
- Арабын гурав: Кувейт, Палестин, Иордан;
- Мөн Австралийн Элчин сайд нар ирсэн байлаа.

Биднийг цайлсны дараа Ерөнхийлөгчийн Ёслолын албаны хариуцлагатан хоёр эрхэм ИЖБ-г хэрхэн яаж барих талаар газар дээр нь сургуулилахаар бөөнөөр нь дагуулан гарлаа. Египетийн Ерөнхийлөгчийн ёслолын журмаар бол ИЖБ барьж байгаа гадаадын Элчин сайдад 1 минутаас илүү хугацаа өгдөггүй, Төрийн тэргүүнтэй юм ярихгүй, зэрэгцэж зогсохгүй, дөхөж очихгүй юм байна. Төрийн дуулал 1 бадгийг эгшиглүүлэх, жуух гардуулах, хүндэт зочдын дэвтэрт гарын үсгээ үлдээхэд нийтдээ 5 минутаас илүү хугацаа зарцуулдаггүй гэв. Айхтар шахуу ёслол байна.

ИЖБ-г хэрхэн яаж барих талаар хичээллэсний дараа 10.30 цагаас эхлэн жагсаалтад бүртгэгдсэн (Каирт ирсэн он, сар, өдрөөрөө) дарааллын дагуу нэрээ дуудуулан нэг нэгээрээ цувран гүйлдэж эхлэв. Эхнийх нь 2007 оны 10 дугаар сараас хүлээж байгаа Мальта улсын Элчин сайд салхи хагаллаа. Харьцуулваас бид нэг эмчийн үүдэнд оочер хүлээн суугаа өвчтөн аятай, сувилагч нь гарч ирээд л номерыг нь дууддаг даа. Яг тэрэрхүү л юм шиг. Эелдэг үг, ёслол хүндэтгэл гэж байхгүй л улсынхаа нэрийг дуудуулаад л чавхдаад байх нь тэр. Миний бие 13 дугаарт бичигдсэнээрээ 11.05 цагт бослоо. Ёслолын танхимаар дамжин гадна довжоон дээр тусгайлан зассан хивсэн дээр очиж зогсмогц ёслолын хоёр ажилтан хоёр талд зогсов. Хүндэт харуул командаар сэлэмт ёслол үйлдсэний дараа манай улсын Төрийн дууллыг нэг бадгийг эгшиглүүлэв. Төрийн далбаа мандуулсан нь харагдсангүй.

Залгаад танхим руу эргэн аажуухан алхсаар гол танхимд орж, Ерөнхийлөгч Х.Мубаракийн зогсож буй зүг хүрэв. Тэнд Ерөнхийлөгчид тусгайлан зассан нэг том торгон хивс, Элчин сайдад зориулан зассан нэг жижиг торгон хивс байна. Тэр хивснээс урагшилж

алхаж болохгүй журамтай. Тэнд очиж номхон зогсоод Ерөнхийлөгч Х.Мубаракийн нүд рүү эгцлэн харж, чанга дуугаар:

- Ambassador of Mongolia to the Arab Republic of Egypt Prof. Dashdorjiin Bayarkhuu. I have the honor to present my Credentials, Your Excellency! гэж хэлээд ИЖБ-ээ дугтуйнаас нь гаргалгүй гардуулав.

Ерөнхийлөгч Х.Мубарак ИЖБ-г хүлээн аваад баярлалаа хэмээн англиар хэлж гар барьснаар үндсэн ёслол дуусч би гэдрэг буцан, чигээрээ алхсаар зочдын дэвтэрт гарын үсэг зурдаг тасалгаанд хүрэв. Тэнд нэгэн том, шугамтай дэвтэрт өөрийн нэр, албан тушаалаа англиар бичсэнээр ИЖБ барих ёслол өндөрлөлөө.

Ёслолыг дуусгаад гарч ирэхэд өглөө нь ЭСЯ-наас авсан ёслолын хар тэрэгт урьж суулгалаа. Эртнээс, 3 сарын өмнөөс шаардан байж авсан манай төрийн жижиг далбааг мандуулаад буцах ёстой байтал далбаа маань байдаггүй, миний асуусныг үл тоосон янзтай авч хөдөллөө. Ерөнхийлөгчийн ордны хашааны гаднаас өглөөний мотоциклч өмнө маань орж давхилаа. Далбаа яасан бэ гэдгийг жолооч маань мэдэхгүй, англиар ойлгодоггүй гэдгээр дохиж зангаж өнгөрөөв. ГХЯ-ны Ёслолын албаныхны өгсөн 25 улсын далбааг хольж хутгаад олсонгүй юу, эсвэл ГХЯ-наас өгөөгүй юм уу, мэдэж чадсангүй. Буцах замдаа саадгүй явсан боловч ЭСЯ-ны хавьд ирээд мотоциклч маань төөрч будилан, буруу замаар давхиулаад би өөрөө жолоочид нь зааж занган газарчилсаар ЭСЯ-ндаа хүрэв. ЭСЯ-нд ирмэгцээ жолооч, мотоциклч нарт ундаа, жигнэмэг, жимс зэргээр үйлчилж тус бүрт нь 50 фунт өгч, талархал илэрхийлээд явууллаа. Миний өмнөх Элчин сайд Ч.Болд ч тийм хэмжээний мөнгө өгсөн юм билээ. Маргааш нь буюу 2008.06.17-нд Египетийн өдөр тутмын араб хэл дээрхи 4 гол сонинд ИЖБ барьсан тухай мэдээ зурагтайгаа нийтлэгджээ. Нөгөө 25-ыг чинь цувуулаад жагсаачихаж, өмнө нь ганц том босоо зураг байхаар монтажлжээ. Тэр 25 дотор АНУ, Хятад, Британи, Индонез гээд их ба бүс нутгийн гүрний төлөөлөгчид оролцсоноороо, мөн 25 гэдэг энэ тоондоо бидний ИЖБ барих ёслолын гол онцлог байх шиг санагдаж билээ.

Ингээд би албан ёсны Элчин сайд болж байгаа нь энэ юм. Үе шатыг жагсаавал:

1. ГХЯ-наасаа Засгийн газрын хуралдаанд өргөн баригдах
2. Засгийн газрын хуралдаанаас Ерөнхийлөгчид танилцуулагдаж зөвшилцөөд УИХ-д өргөн баригдах
3. УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар батлагдах
4. УИХ-ын нэгдсэн чуулганаар батлагдах
5. Монгол Улсын ГХЯ Египетийн ЭСЯ-нд хандаж агреман ноотоор асуух

6. Египетийн ГХЯ агреманьг зөвшөөрч хариу өгөх
7. Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргах, ИЖБ-ийг гардуулах
8. ИЖБ-ийн хувийг АБНЕУ-ын Гадаад хэргийн сайдад гардуулах
9. ИЖБ-ээ АБНЕУ-ын Ерөнхийлөгчид өргөн барих

Ийм 9 үе шатаар дамжин Элчин сайд болж байна. Амаргүй байгаа биз. Монгол Улсын Ерөнхийлөгч л томилчихвол шууд Элчин сайд болчихдог гэж манайхан хялбаршуулж болдог тул би ийнхүү үе шат бүрээр нь задлан бичиж байгаа хэрэг.

Каирт очоод дав даруй хийж эхлэх нэг чухал ажил байлаа. Дипломат корпус бол бүх дипломатч нарт маш чухал боломж, орон зай юм. Тэдний амьдралын үлэмж хэсэг нь тэнд өнгөрдөг. Дипкорпусын гишүүд бол юуны өмнө бусад мэргэжлийн хүмүүсээс нэлээд ялгарсан, мэргэжлийн эв санааны нэгдэлтэй, мэргэжлийн ашиг сонирхлоороо нэгддэг тусгай анги хүмүүс л дээ. Тэр утгаар миний хувьд Каирт очсон даруйдаа танилцах, хүрээллээ, ижлээ олох, хэл ам авалцах тал дээр би шуурхайлан ажиллав.

Каирт Элчин сайд нар нь Дипломат корпусын ахлагчдаа ёс төдий харъялагддагийг олж мэдлээ. Камеруны Элчин сайд ноён Абдуллах Исмалиа гэдэг хүн 1987 оноос хойш тасралтгүй 21 жил Каирт суужээ. Тэр нөхөртэй уулзах гэснээ болилоо. Нэмэргүй, тэгээд ч буцах гэж байгаа хэмээн манай зөвлөх зөвлөлөө. Харин давын өмнө би Азийн Элчин сайд нарын бүлэгтээ элсэх ёстой юм байна. Бүс нутгаараа бүлэг болж дотроосоо ахлагчаа сонгож, сар бүр ажлын уулзалт, зоог зохион байгуулдаг уламжлал энд хэвшжээ. АБНЕУ-д суугаа Азийн орнуудын Элчин сайд нар, тэдний гэргий нар гэж тусдаа хоёр бүлэг одоо ажиллаж байна. Азийн бүлэг гэдэг нь Ази, Номхон далайн 20 гаруй улс орныг хамарч байна.

Азийн бүлгийн Элчин сайд нар сар бүр уулзалт хийж, суугаа оронтой явуулж буй хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны талаар харилцан мэдээлэл солилцдог уламжлал тогтжээ. Чингэхдээ Азийн бүлгийн орнууд үсгийн дарааллаар уригч болж уулзалтыг зохион байгуулах, уулзалтын дараа ажлын зоог барих ёстой. Энэ үүргийнхээ дагуу би нөхдийнхөө хамт 2008 оны 10 дугаар сард “Dragon House” хэмээх хятад, тай, энэтхэг хоолны ресторанд Азийн Элчин сайд нарын уулзалтыг амжилттай зохион байгуулж анхны оноогоо авлаа. Эхнэр маань ч Азийн дипломатч гэргий нарын нийгэмлэг гэдэгт идэвхтэй яваа. Мөн л ЭСЯ-ндаа тэднийг хүлээн аваад уулзалт зоог амжилттай зохион байгуулчихсан.

Дипломатчдыг холбох нийтлэг зүйлс бишгүй олон. Мэдээлэл эрэн сурвалжлах нийтлэг сонирхол, мэдээллээ солилцох арга хэлбэрээс эхлээд шинэ нутагтаа (бүгдэд нь хоёр дахь түр эх орон нь) дасах, оршин суух,

гэр бүлээ төвхнүүлэх гэхчлэн хувийн асуудлууд төстэй байдаг тул жаргал зовлонгоо хуваалцахаар нөхөрлөхөөс аргагүй. Энэ бол дипломатчийн хувьд бүр амин чухал даваа байдгийг би сайн мэднэ. Адаглаад л хүүхдийн сургуулийн асуудалтай тулгарна. Лалын энэ том оронд, энэ халуун цөлд, удаан үргэлжилдэг халуунд нь чөлөөт цагаа хэрхэн өнгөрөөх, хэрхэн ийш тийш зорчих, хавсран суугаа орондоо хэрхэн ажиллах гэх мэт нийтлэг “бэрхшээлийн” өмнө бид аргагүйн эрхээр “нэгдэн нягтардаг” ба тэдгээрийг шийдвэрлэх арга замыг хамтран эрэлхийлдэг. Энэ талаар дооз нь хэтэрчихгүй бол би ч гацах зүйлгүй л дээ.

Би одоогоор ТУХН, Латин Америкийн Элчин сайд нарын бүлгийн албан бус гишүүн болох шахуу дотно нөхөрлөлийг (бараг бүгдтэй нь) тогтоогоод байна. Африкийн бүлгийн сайд нараас ч найз олонтой. Намиби, Лесото, Этиоп, Ангол, Камерун, Чад, Кот д’Ивуар, Мали, Гвинейн гээд олон Элчин сайдтай найрсаг харилцаатай. Ингэхэд хөрш маань хэнсэн билээ. Манай тэр хавьд гэвэл манай өмнөх гудамжинд Буркина-Фасогийн ЭСЯ бий. Би сайдтай нь гэмгүй, хөршүүд гээд сүйд болдог. Нэлээд цаашхинаа явбал төв зам гараад ӨАБНУ-ын Элчин сайдын өргөө бий. Урагшаа эргээд хэсэг алхвал Парагвайн Элчин сайдын өргөө бий. Тэр нөхөртэй би үнэхээр найз, хэд хэд уригдсан. Парагвайн Гадаад хэргийн сайдыг айлчлахад оройн зоогт нь цөөхөн хэдхэн Элчин сайд уригдахад би очиж байлаа. Манайхаас баруун урагшаа хэсэг явбал Японы ЭСЯ бий. Элчин сайдынх нь өргөө хотын төвд. Гэх мэт эргэн тойрноо баримжаалж болно. Ер нь би бол одоо оршин суугаа энэ Маади дүүргийнхээ ДТГ-ын Тэргүүн нарын албан бус клубыг байгуулах санаачлагчдын нэгэнт тооцогдож яваа.

Суугаа энэ орондоо болон хавсран суугаа 4 улсдаа, хавсран хариуцаж байгаа 10 улсдаа, өргөн утгаараа Африк тивд монгол иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах гэж нэг лут үүрэг бидэнд байдаг юм. Олон улсын харилцаанд энэ асуудал голлох байр эзэлж, аль ч улс орон иргэдийнхээ эрх ашиг гэдгийг тэргүүн зэрэгт тавьж байгааг тусгал болгон бид ийм бодлого явуулах нь зүй ёсны хэрэг. Одоогоор Аль-Азхар хэмээх лалын их сургуульд суралцаж байгаа 30 гаруй оюутан Каирт байна. Энэ бол суннит исламыг судалдаг дэлхийн гол төв сургууль, нэн эртний түүхтэй (975 оноос), тэнд манай хасаг залуус лалын шашны гүн ухаан, араб хэлэнд шимтэн суралцаж, зарим нь гэр бүлээ авчраад төвхнүүлж байдаг юм байна. Гадаадад л гарчихвал аз жаргалтайгаа золгочихно гэх анхны сэтгэхүйдээ хөтлөгдөөд араб, африк айлд бэр болоод ирсэн ганц нэг монгол бүсгүй байх бололтой. Египетэд 2-3, Ливид нэг, Эмиратад нэг, Нигерид нэг, эх нь Монголдоо хоёр үр нь Сирид гэхчлэн. Биечлэн уулзсан нь ганцаас хэтрээгүй, тэр нэг тиймхэн

байна. Тэгээд ч ЭСЯ-н руугаа хандаад ирэхгүй тул өөрийгөө шууд зэмлэх нь юув. Интернэт хөгжсөн өнөө цагт харилцаад болоод байна.

Ингэхэд Египет дэх бидний амьдрал хэр төвхнөсөн талаар сонирхуулах юм юусан билээ. Зөндөө л юм байна. Оршин суугаа Maadi (Маади) дүүргээсээ эхэлье. Манай энэ дүүрэг бол Каир хотын төвөөсөө нэлээд алслагдмал, лав ГХЯ орох гэж 30-40 минут өлхөн явна. Нил мөрөн урсаад хотоор нэвт гардаг гэж үзвэл эхээд нь гэх үү дээ. Ертөнцийн зүгээр бол өмнө этгээдэд. Шинэ, хуучин хоёр Маади байна. Манайх хуучинд нь, ихэнхи ЭСЯ, Элчин сайдын өргөө шинэд нь. Шинэ хуучныг зааглах метроны төмөр зам байна. Шинэд нь гадаадынхан их амьдардаг юм билээ. Орчин үеийн түүхэнд Маади маань бас нэг “баатар”-тай. “Аль-Каеда” хэмээх террорист байгууллагын нэг удирдагч, одоо бол бүр гол удирдагч нь Айман Мухаммед Рабайе аль-Завахири гэгч египет нөхөр Каирт төрөөд энэ Маадид өсч торниод, 1960-аад онд Маадид дунд сургуулийг дүүргэжээ. Дараа нь Каирын их сургуулийн хүн эмнэлгийн салбарт суралцаж төгсгөөд бас энэ Маадийн нэг эмнэлэгт мэс засалч байсан бололтой. Ийм цуутай газар бид одоо аж төрж байна. Хэрэв барууны аль нэг орноос ирсэн зочин манай энэ хуучин Маадид суурьших гэвэл нэлээд бэрхшээлтэй тулгарах байх. Эргэн тойрон хог новшиндоо дарагдсан, муур нохой нь дийлдэхээ больсон, хиншүү хярвас үнэртүүлсэн хоолны газар, зах зээл нь хөглөрсөн, хүн машин нь холилдсон, ер нь юу ч гэмээр юм. Гэвч дасдаг юм байнаа.

Бид (ер нь монголчууд) халуун яг шатаж эхэлж байхад ирсэн тул цаг агаарын бэрхшээл тулгарч таарна. Биднийг ирэхийн өмнөхөн +37 хэм хүртэл халж нэг сандаргасан юм билээ. Тэгээд л 4 дүгээр сараас халуун нь шатчихав. Энэ цөлд хур бууна, тэнгэр бүрхэнэ гэж ёстой гонж доо. Зундаа ямагт +30-аас дээш, хааяа +40-ийг давна. Тэгээд бороо орохгүй, хурц нар төөнөөд л. Гэм нь хүчилтөрөгч илт дутагдана. Сэнгэнэсэн агаарыг ёстой нэг хүсэх шиг болно доо. Элсэн цөлд боссон эртний том хот, бараг 25 сая хүн бужигнаж байдаг, хотжилт нь экологийн баахан асуудал дагуулчихсан, үүр шөнөөр лалын мечетийн мөргөлийн дуу хадаад, ер нь шууд дасахад ч бас амаргүй л дээ. Нутаг дэвсгэрийнх нь 95 хувийг цөл эзэлнэ. Иймд хүн амынх нь 90 хувь нь нутаг дэвсгэрийнхээ 3-хан хувьд буюу энэ улсын цорын ганц гол болох Нил мөрнийхөө эргийг бараадан аж төрнө.

Ажлын цаг, дэг нь манайхаас шөл өөр. Халуун их шатдагаас болдог байх, хүмүүс нь аажуу наазгай, цаг баримталдаггүй, санаатай биш ч худал хэлчихдэг тал бий. Энд өглөө хэдэд ажил эхэлдэг, өдөр, орой хэзээ завсарладаг тардагийг мэддэг гадаадын хүн гэж байхгүй байх аа. ГХЯ нь 10.00 цаг өнгөрч байхад цуглаад үдийн

завсарлагагүйгээр орой 18.00 хүргэдэг гэлцдэг. Бусад байгууллагыг ёстой бүү мэд. Долоо хоногийн баасан гаригийг “Жума” гэж нэрлэнэ. Их мөргөлийн өдөр гэсэн үг юм уу даа. Тэр өдөр бүтэн өдөржин мөргөөд маргааш нь амарна. Нямд шинэ 7 хоног эхэлнэ. Лалынхан баасанд, жүүдүүд бямбад, христосчууд нямд мөргөдөг ёсон буй.

Каир хот гэхэд л бараг насаараа үзээд баршгүй их түүх дурсгалын газартай. Эрт үед энэ хотыг “Египетийн Вавилон” гэж нэрлэж байсан юм гэсэн. Манайхны сайн мэддэг бөгөөд үзэхийг хүсдэг ганц үзмэр нь пирамид юм. Хеопс, Хефрен, Микерин гэсэн гурван цац суварга, мөн их Сфинкс нь Гиза хэмээх хотод бий. Би ч хэд хэдэн удаа зочлоод авсан. Хан-эль-Халил хэмээх зах руу манайхан их хушуурдаг юм билээ. Египетийн музей, Мухаммеда Алийн мечет, Салладины цайз гэж Каирт байна. Энэ бүхнийг үзэх хүсэл надад бий. Яаж ийгээд амжуулна даа. Луксор хот руу явж Карнак хэмээх сүм, Тутанхамоны бунхныг үзэх хүсэл төрөвч одоогоор амжаагүй явна.

Улаан тэнгисийн эргээ дагасан үй олон курортуудаараа энэ орон алдаршсан. Иймд бид, манай ЭСЯ-ныхан баасан гаригийг товлоод л Улаан тэнгис рүү гарч өгнө шүү дээ. Эрүүл агаарт гарч, далайн усанд умбах шиг аз жаргал гэж энэ халуун цөлд өөр юу байхав. Манайхан тэнд өөрийн гэх бяцхан пляж нээсэн юм билээ. Каирын зүүн өмнө дүүрэгт байдгийнх, бид хотоосоо гараад далай явахад арай дөхүү юм. Багцаагаар 140 км яваад Соухна (Ain Soukhna буюу халуун рашаан гэсэн үг гэнэ лээ) гэдэг газар хүрнэ. Тэнд Портрэйт гэж буудлын цаахна их замын хажуугийн зайнд паркаад цаашаа эрэг рүү ормогц шууд далайн эрэг байх тийм газар бид очдог байлаа. Тэнд хүүхэд тогложихоор элстэй, далайд нь есөн жорын загас жараахай, зараа, хавч, дун, ургамал элбэг. Усан доогуур сэлээд явж байхад далайн гүний амьдрал тэр чигээрээ дор мэлтийгээд л, цаагуур нь дельфин өдөртөө хоёр удаа сүргээрээ нааш цааш сүлжилдэнэ. Ус нь хүртэл халуун рашаан гэдгээ нотлох мэт. Сэлж явахад заримдаа гэв гэнэт цэл хүйтэн ус руу ороод ирнэ, тэгснаа халуун судлууд дороос ундраад л. Европ, Америкаас олон мянган евро, доллар төлөн байж ирдэг жуулчны аяллыг бид үнэ төлбөргүй Каираасаа эдэлж байгаа хэрэг шүү дээ. Palm Beach Resort гэж бас нэг нөөц пляж бидэнд бий. Каир дахь дипломат корпусынханд зориулсан, тохилог, гол нь арабчууд шавахгүй, манай хүүхнүүд тааллаараа сэлж сэлгүүцэж болно. Гэм нь ус нь татрахаар гүехэн болчихдог. Бас нөгөө есөн жорын загас жараахай, зараа, хавч, дун, ургамал нь ойр хавьд байхгүй.

Суугаа орноороо аялан зугаалах, юм үзэж нүд тайлах, амралт ажлыг хослуулах миний өөрийн хобби манай хамт олныхтой хоёр талаасаа авцалдсан юм байх. Бид Улаан далайн эргийг ч ёстой нэг нүхлэх шиг

болж байна. Эхлээд Африк талын эргээрээ хойшоо давхиж Суэц хотод очиж хоноглов. Эргээ дагаад доошоо нэлээд явж үзлээ. Пляж, буудал хайгаад л, тэгж тэгж хамгийн боломжийнх нь Portrait (Портрэйт) болж таараад тэнд байнга буудаг боллоо. Бараг шефийн харилцаа тогтсон байх. Зочин ирэхэд амар юм. Хол давхихгүй, далай нь байж байна, дельфин үзэж болно. Буудал нь тохилолог, цэлгэр том том өрөөтэй, томоос том ортой, хоногтоо хоёр удаа хооллоно, хоол нь дажгүй.

Гэтэл нөгөө эрэгт, Синайн хойгт байгалийн хачин сайхан халуун рашаан байна гэдгийг курсынхнээс дуулаад тийшээ зориглоод гарч өгөв өө. Талдаа 280 км, цөлд, тэгээд баримжаагаар, аман яриагаар хөдлөж байгаа хэрэг шүү дээ. Суэц доогуур татсан тунелээс цаашаа 110 км-т гэсэн тул баримжаатай. Ер нь тэр хавьдаа 15 рашаан бий гэнэ. Эртний фараонууд энд тухлаж байсан гэж ном зохиолд бичжээ. Фараоны банн гэж ч нэрлэдэг юм байна. “Hamampharoun Nature Warm Springs” гэсэн хаягийг хайгаад л давхиад байлаа. Нэлээд эрэл сурал болсны эцэст олж очлоо. Байгалийн агуй нь тэр чигтээ сауна юм байна. Хүхэр үнэртсэн бүгчим агуй байна. Хүхэртэй халуун рашаан нь газрын гүний судлаар дамжаад шууд далайд цутгаж байна. “Усан дор гал асаж байна” хэмээн Коран судард бичсэн нь энэ гэнээ, рашаанчин арабчуудын ярихаар. Орой тэндээсээ буцаад зам дагуу буудал хайлаа. Sudr Beach Inn гэж нэг даруухан жижиг буудалд буулаа. Дараагийн явалтаар Moon Beach Resort гэж гайгүй тохилог буудал олж тухаллаа. Одоо энэ буудалтай шефийн харилцаа тогтооно доо.

Египетийн хоёр дахь том хот Александриаг энэ мэт аялахдаа хэд хэд элээгээд авлаа. Алба амь хослуулаад очлоо. Энэ хотыг Македоны Александр хаан манай эриний өмнөх 332-331 онд үндэслэсэн ба тэр үедээ грекийн уран барилгын ур хийц, Эллиний соёлыг Африкт түгээсний шинж тэмдэг одоо хүртэл мэдрэгдэж байх шиг санагддаг. Александриа хотын “Александрина” гэж дэлхийд алдартай нь номын санг үзэх сэтгэл хэн хүнд төрөх нь гарцаагүй. Өнө эртний түүхтэй дэлхийн анхны номын сан гэнэ билээ. Сан хөмрөгт нь 4000 жилийн өмнөх гар бичмэл бүхий нийт 600 000 ном хадгалагдаж буй, бүх номоо цахим хэлбэрт шилжүүлсэн, хамгийн орчин үеийн өвөрмөц уран барилга, цахим техник, уншлагын танхим, хурлын заал, музейнуудаараа алдартай, зочид гийчид, жуулчдын хөл тасардаггүй газар юм байна. Би лав нэг жилд 3 удаа тийшээ зочилсон юмдаг. Дэлхийд цар хэмжээ, үйл ажиллагаагаараа хоёрдугаарт (АНУ-ын Конгрессын номын сангийн дараа) ордог тус номын санг нь манай Үндэсний номын сантай шууд харилцаа тогтоолгож хамтын ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна.

Александриа хотод 500 жилийн тэртээх Туркийн эзэгнэлийн үеийн цайз далайн хөвөөн дээр бий. Түүнийг Султан Ашраф XV зуунд

бариулсан аж. Энэ бол жуулчдын нэг чухал маршрут. Ромын эзэнт гүрний үеийн анфитеатрын туурийг заавал үзэх хэрэгтэй. Каираас Александриа хүртэл 225 км, хурдны замаар 2 цаг гаруй давхиж хүрнэ. Каирыг бодоход тэнд халуун шатах нь гайгүй, ядаж тэнгэрт нь үүлтэй, бороо хур ордог, тэгээд ч далайн хөвөөн дээр тул зөөлөн чийглэг уур амьсгалтай. Ажлын далим л гарвал би Александриа орохоос ер буцахгүй. Зуны цагт далай нь их сүрлэг. Хөөсрөөд л, давалгаа нь тээр дээр гарч ирээд л. Тэр давалгаанд нь шиддүүлээд сэгсчүүлээд сэлж явахад ёстой нэг эрийн хийморь сэргэмээр. Хамаг амьсгаа огшоод л.

Африкийн элсэн цөлд олон жилийн халууныг туулна гэдэг тавь гарсан мань мэтэд хэцүү байвч бас ажил маань сонирхолтой, ам бүл маань хамт байгаа болохоор ажрах нь гайгүй. Гэвч миний насныханд, ерөөсөө ЭСЯ-ынханд нэгэн хэрэгтэй чухал зүйл байдгийг би санан санан Каирт очсон юм. Энэ бол эмнэлэг, эмчилгээ. Би судалгаа хийгээд үзтэл байнгын Элчин сайдын яамаа 1967 онд Каир хотноо нээснээс хойш ЭСЯ-ны нийт хамт олныг суугаа орны эрүүл мэндийн даатгалд хамруулах талаар манай улс ямар нэг тодорхой алхам огт хийж байгаагүй дүр зураг харагдаадхав. Төвөөс ямагт бие сайтай, өвчилдөггүй хүмүүсийг томилж ирүүлж байсан бололтой, эсвэл захиргаадалтынхаа аргаар “Өвчилж болохгүй!” гээд үүрэгдчихэж. Хөнгөхөн өвчилбөл Зөвлөлтийн ЭСЯ-ны дэргэдэх эмнэлэгт үзүүлдэг, хүндээр өвчилбөл эх орондоо эмчлүүлдэг гэсэн зарчим 1990-ээд оныг хүртэл үйлчилж ирсэн юм байна. 1990-ээд оноос энэ үйлчилгээ ч алга болсон, ингээд өнгөрсөн 17-18 жилд манай ажилтнуудад үзүүлдэг, эмчлүүлдэг тогтмол эмнэлэг байхгүй, өвчлөхгүй бол аз гэсэн зарчмаар өнөө хүрсэн байжээ. Ингээд би Элчин сайдаар томилогдон ирснээсээ хойш даатгалын талаар судалгаа хийлгэж үзлээ. Даатгуулах нь ашиггүй, хэрэв өвчлөхгүй бол даатгуулсан мөнгө тэр жилдээ эргээд олдохгүй, тэгээд ч ЭСЯ-ны төсөвт суулгаж өгсөн 2000 ам.доллар нь 4 гэр бүлийн гишүүдийн даатгалд хүрэхгүй, ер нь даатгалын тогтолцоо Египетэд сул, манайхны араб хэлний бэрхшээл зэргээс шалтгаалан энэ асуудлыг бид түр хойшлуулахаар шийдлээ. Одоо яахав. Манай ЭСЯ оршин байгаа энэ Маади дүүргийнхээ “Аль Фарук” хэмээх хувийн эмнэлэгтэй хамтран ажиллах талаар хасаг оюутнуудаараа хэлмэрчлүүлэн хэд хэдэн удаа хэлэлцээ явуулсны дүнд ЭСЯ-ны ажилтнуудыг тэр эмнэлгээр үйлчлүүлж байх тухай хэлэлцээр байгуулан 2008.08.01-нээс мөрдөж эхэллээ. Хэлэлцээрээр бол “Аль Фарук” эмнэлэг манай ажилтнууд, тэдний гэр бүлийнхэнд хөнгөн шуурхай, чанартай үйлчилнэ, египет иргэдийн адил хөлсөөр төлбөр авна, төлбөрийг улирал ба жилийн эцэст бөөгнүүлэн тооцно, харин ЭСЯ-ны ажилтан мөн, гэр бүлийнх нь гишүүн мөн гэдгийг нотолж Элчин сайд гарын үсэг зурж бичиг шийтгэн олгох ёстой гэж тогтов. Элчин сайд хүний зайлшгүй хийх

ёстой энэ ажлыг амжуулсныхаа дараа өөр дээрээ туршихаар шийдлээ. Ингээд огтоос таньж мэдэхгүй араб эмнэлэг, араб эмч нарт эрүүл мэнд, амь насаа даатгаад цесний чулуу авахуулах мэс ажилбарт орлоо. Үр дүн нь тун сайн явна.

Хоёр орны харилцааг идэвхжүүлэх талаар элдэв санал санаачилга гарган хөөцөлдөж байгаа ч үр дүнг нь үзэхэд арай эрт байна, бас ч үгүй нэлээд хугацаа орох болов уу. Ямар ч атугай дээд боловсрол, шинжлэх ухаан, номын сан, мэдээллийн технологийн шугамаар хамтын ажиллагааны эхний алхмууд хийгдэж эхлээд ажил явж байна. Монгол-Египетийн харилцааны хамгийн бодитой, одоохондоо цорын ганц гэмээр хэлбэр болох Египетийн сангийн тэтгэлэгт курсын сургалтыг үргэлжлүүлэх, өргөжүүлэх, гүнзгийрүүлэх талаар эрчимтэй ажиллаж байна. ГХЯ-ных нь дэргэд ТУХН-ийн орнуудтай Техникийн хамтын ажиллагаа хөгжүүлэх Египетийн сан гэдгийг 1993 онд байгуулсан ба манай улс 1997 оноос сангийн тэтгэлэгт хамрагдаж эхэлснээс хойш Египетэд суралцсан сонгогчдын нийт тоо 1000-аас давжээ. Энэ бол чамлахаар үзүүлэлт биш. Цаашдаа ч өснө. Аль болох илүү олон монгол хүн энэ тивд, энэ улсад хөл тавьж, юм үзэж нүд тайлж, мэдлэгээ арвижуулж яваасай гэж би боддог, хэлдэг, уриалдаг юм. Түүнийгээ ч мөрдөн ажиллаж байна.

Энэ мэт ажил амьдрал маань Миср нутагтаа үргэлжилж байна. Ер нь энэ нэг жилдээ үзсэн харсан, зочилсон, уулзсан болгоноо бичнэ гэвэл дахиад хэдэн хуудас өлхөн дүүрэхээр байна. Миний хувьд Египет шиг ийм их үүх түүхтэй орны түүх, соёл, орчин үеийн хөгжил, ард түмний нь амьдрал, байгаль орчинтой танилцахад томилолтын хугацаа маань даан ч давчдана л даа. Гээд цаг мөч бүрийг алдахгүй юмсан.

Миний бие Каирт ажиллах үедээ, Булангийн 4 оронд хавсран суух Элчин сайд, түүний дотор Саудын Арабт суух анхны Элчин сайдын үүрэгт ажлыг хавсран гүйцэтгэх хувь давхар тохиож байна. Энэ бол тэр бүр Элчин сайд бүрт олдоод байх хувь заяа, завшаан биш. Энэ үүргээ үлгэр жишээчээр биелүүлнэ гэж бодож яваа.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Урианхан Б.Жаргалсайхан. Алаг жарны бодрол, *Интерпресс* хэвлэлийн газар, 2001, 215 дахь талд
2. Тэр үеийнхээр шүү дээ, одоо хэд болсныг мэдэхгүй. Эрхбиш өссөн байж таарна.
3. Энэ бол шинэчилсэн хамгийн сүүлчийн тоо баримт биш. 2007 оны жагсаалтаас эшлэж байна. АБНЕУ-ын ГХЯ нь “Diplomatic & Consular List” лавлах номоо хэвлээгүй хоёр жил болж байна. Хэвлэнэ гээд л нэрс аваад байсан. Хэрэв тэр хэвлэгдвэл миний энэ эшлэсэн тоон дээр өөрчлөлт гарч магад.